

Танай үйлдвэр байгалийн гамшигт ноцтой өртөх боломжтой юу?

2018 оны 1-р сар



Сүүлийн жилүүдэд дэлхий даяар олон байгалийн гамшиг тохиолдож буй талаар мэдээлэгдсээр байгаа билээ. Өгөгдсөн зургуудаас зарим жишээг нь харж болно:

1. 2016 оны 5-р сард сансрын хиймэл дагуулаас дарсан буюу Канад улсын Альберта мужийн Форт МкМуррайд гарсан гал түймрийн зургийг ажиглахад тус хэсгийн ойролцоо тос боловсруулах байгууламжууд байрлаж байна.
2. Форт МкМуррайд гарсан гал түймрийн зураг
3. 2017 оны 8-р сард тохиолдсон Харви хар шуурганы хүч хамгийн дээд цэгтээ ойртсон буюу Техас мужийн далайн эрэг рүү дөхөж буй үеийн зураг
4. Техас мужийн Хьюстонд Харви хар шуурганы улмаас тохиолдсон үерийн зураг
5. Харви хар шуурганы дараа эрчим хүч тасарсантай холбоотойгоор хөргүүрийн систем ажиллагаагүй болсон учир боловсруулах үйлдвэрт органик пероксид агуулсан савнууд дэлбэрсэн.
6. 2011 оны 3-р сард Япон улсын Фукушима Дайчигийн цөмийн эрчим хүчний станцад томоохон хэмжээний газар хөдлөлт, түүнийг дагалдсан цунамигийн улмаас эрчим хүч тасарсан. Үүнтэй холбоотойгоор хөргөлт хангалтгүй болсон учир гурван ширхэг цөмийн реактор хайлж, дэлбэрэлт үүссэн ба радиоидэвхт материал алдагдсан.

Эдгээр тохиолдлууд болон үүнтэй төстэй ослоуд нь боловсруулах үйлдвэрүүдэд ноцтой нөлөө учруулах боломжтой, учруулсаар байгаа юм.

Та юу хийж чадах вэ?

- Үйлдвэрийнхээ байгалийн гамшигийн үед мөрдөх журмыг мэддэг байх, онцгой байдлын үед бэлдэх, хариу арга хэмжээ авах, сэргээн босгохтой холбоотой өөрийн гүйцэтгэх үүрэг хариуцлагыг ойлгосон байх хэрэгтэй. Танай үйлдвэрт нөлөөлж болзошгүй гамшигийн төрөл нь үйлдвэрийн байршлаас буюу тухайн хэсэгт ямарүзэгдэл тохиолдох боломжтой вэ гэдгээс хамаарна.
- Танай онцгой байдлын үед мөрдөх журамд газар хөдлөлт, хар салхи гэх мэт зарим төрлийн байгалийн гамшиг нь хэсэг хугацааны өмнө урьдчилан мэдэх боломжтой эсвэл ямар ч сэрэмжлүүлэггүйгээр гэнэт тохиолдож болзошгүй талаар тусгасан эсэхийг шалга.
- Боловсруулсан төлөвлөгөөнүүдэд байгалийн гамшигийн үед болон дөнгөж дараахан нь талбайд дээр байх ажилчдыг тусгасан эсэхийг бататган нягтал. Тэдгээр ажилчдад тусламж дэмжлэг (хоол хүнс, орон байр, харилцаа холбооны хэрэгсэл гэх мэт) шаардлагатай бөгөөд тухайн үед зам харилцаа болон бусад олон нийтийн үйлчилгээ тасалдах боломжтой юм.
- Таны хариуцсан хэсэгт, ялангуяа дээр дурдсан органик пероксид дэлбэрсэн жишээтэй адил үйлдвэрлэлийн тодорхой аюул бүхий цэгт, байгалийн гамшиг хэрхэн нөлөөлж болох талаар ойлголттой байх хэрэгтэй. Гамшигийн үед мөрдөх Аврах төлөвлөгөөтэй танилцаж, танай ажлын талбайд бүрэн тохирч байгаа эсэхийг нь нягтал.
- Та аль нэгэн төлөвлөгөөнд тусгагдаагүй боловч чухал гэж бодож байгаа зүйл олж илрүүлсэн бол ахлах ажилтандаа мэдэгдэх нь зүйтэй ба ингэснээр тухайн төлөвлөгөөг улам сайжруулах боломжтой юм.
- Байгалийн гамшиг тохиолдсоны дараахан ажилчид ажлаа тайлагнах боломжгүй эсвэл сайтын ажилчид гэртээ харих бололцоогүй байх тохиолдол гарч болзошгүй. Эдгээр магадлал болон ажиллах хүч хязгаарлагдмал байх нөхцөл зэргийг төлөвлөгөөндөө тусгасан байх ёстой.
- Таны ажилладаг, амьдардаг орчинд тохиолдож болзошгүй янз бүрийн гамшигаас хамгаалах хувийн төлөвлөгөөг өөртөө болон гэр бүлийнхэндээ зориулан боловсруул. Та гэр бүлийнхэндээ санаа зовсон үедээ үр нөлөөтэй ажиллаж чадахгүй!
- Байгалийн гамшигт бэлтгэх талаарх нэмэлт зөвлөмжийг 2005 оны 11-р сар, 2011 оны 06-р сарын Beacon-аас уншиж болно.

Аливаа байгалийн гамшигт ямагт бэлэн бай!

© AIChE 2017. Зохиогчийн эрхийг хуулиар хамгаалсан. Арилжаа, худалдааны бус харин сургалтын зорилгоор хуулбарлаж ашиглахыг дэмжинэ. Харин арилжаа, худалдааны зорилгоор AIChE –с бичгээр илэрхийлсэн зөвшөөрөл аваагүй тохиолдолд хуулбарлаж ашиглахыг хатуу хориглоно. Бидэнтэй ccps_beacon@aiiche.org эсвэл 646-495-1371 хаягаар ходбогдоно уу.